



THE ENGLISH SCHOOL OF MONGOLIA

Сургуульд Ирэх/Тарах болон Хоцролттой холбоотой журам

Сургуульд Ирэх/Тарах болон Хоцролттой холбоотой журам

И Эс Эм нь аюулгүй зорчих дүрэм бүхий хувийн хэвшлийн сургууль юм.

1. Энэ бодлолго нь хууль ёсны баримт бичиг бөгөөд И Эс Эм сургуульд заавал дагаж, мөрдөх дүрэм, журмын нэг хэсэг болно.
2. Сурагчид И Эс Эм сургуулийн дүрэм, бодлогыг хүндэтгэн дагах ёстой
3. Сурагчдыг өглөө 8:00 цагаас өмнө ангид орохыг хориглоно.
4. Сурагчдыг хичээлийн цаг дуусахад 16.00 цагаас (Баасан гарагт 15.00) өмнө /эрт/ гаргаж тараахыг хориглоно.
5. Бага сургуулийн сурагчдыг цагтаа аваагүй, тарах цагтаа эцэг эх нь ирж амжаагүй сурагчдыг ангид нь үлдээхгүй ба тухайлсан нэг ангид эцэг эх, асран хамгаалагч нь иртэл харгалзах багшийн хамт үлдээх ба хүлээх сүүлийн хугацаа дуусахад үүдний хэсэгт Шөнийн харуулын ширээний урд үлдээнэ.
6. Оройтож үлдсэн хүүхдүүдийг харгалзах багшийн хамт үлдээх сүүлийн хугацааг Бага сургууль 16:45 минут, Цэцэрлэг 18:10, Гэрийн даалгаврын анги 18:05 минут хүртэл байна. Дээр дурдсан цагаас хоцорч хүүхдээ сургуулиас авсан эцэг эх, асран хамгаалагчид торгууль ноогдуулах ба 10 минут тутамд 10,000 төгрөгөөр тооцон сурагчийн сургалтын төлбөрт нэмж тооцон нэхэмжлэх ба энэхүү үйлдэлийг төлбөр төлөөд үргэлжлүүлээд байхыг сургуулийн захиргаа дэмжихгүй. Сурагчийг оройтож авах үйлдэл 1 улиралд 3-с дээш удаа давтагдвал сургууль өөрийн нийгмийн хариуцлагын хүрээнд хуулийн байгууллага болон Хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагуудад тухайн эцэг эх, асран хамгаалагчийн талаар мэдэгдэх арга хэмжээг авна.
7. Хүүхдээ оройтож ирж авсан эцэг эхчүүд жижүүр дээрх тэмлэглэл дээр Хэний эцэг эх, асран хамгаалагч? Хэн ?, Хэдэн цагт? авсан зэргийг заавал бичиж хүүхдээ хүлээж авна.
8. Зөвхөн 1-р ангийн эцэг эхчүүд тухайн ангийн хэсгийн хувцас солих өрөөнд өглөө 8:00-8:30 хооронд орой тарахад 16:00-с (Баасан гарагт 15:00) хойш орохыг зөвшөөрөх ба бусад цагаар орохыг хориглоно.

9. 2-5 р ангийн сурагчдын эцэг эхийг тухайн ангиудын жигүүррүү орохыг хориглох ба хүүхдээ үүдний хэсэгт хүргэж, авах боломжтой.
10. Ангийн багш нартай өглөө уулзалт хийхийг зөвшөөрөхгүй ба богино хэмжээний чухал /яаралтай/ мэдээлэл өгөх зорилгоор Туслах багштай уулзах боломжтой. Ангийн багштай тухайлан уулзах бол заавал өмнө нь цаг авч байж уулзана.
11. Эцэг эх, асран хамгаалагч нар сургуулийн дотогш нэвтрэх бол ESM VISITOR тэмдэгийг хүлээн авахаас авч зүүнэ.
12. Сурагчдыг сургуульд цагт нь хүргэх/ авах нь эцэг эх асран хамгаалагчийн хариуцлага бөгөөд цаг барьж сургах нь сургалт хүмүүжил цаашлаад хувь хүний зохион байгуулалтад чухал нөлөөтэй.
13. Сурагч сургуульдаа хоцрохгүй ирэх нь түүний хичээлдээ хандах зөв хандлага, цаашлаад сургуулийн хэвийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж эмх замбараагүй байдлыг багасгадаг тустай. Сурагч хоцорч ирснээр хичээл болон бусад сурагчид болон багшдаа саад учруулдаг тул эцэг эх, асран хамгаалагчид хүүхэддээ цаг барьж сурах тал дээр анхааруулан сургах хэрэгтэй. Энэ нь таны хүүхэд бусдын цагийг хүндлэх ухаанд суралцах чухал ач холбогдолтой.
14. Хэрэв сурагч сургуульдаа хоцорч ирсэн бол тухайн хоцорсон шалтгааныг угтах ажилтны хэсэгт байрлах тэмдэглэл хөтлөх дэвтэрт бичиж бүртгүүлнэ. (унтсан эсвэл замын түгжрэл бол хүндэтгэх шалтгаанд тооцохгүй). Хоцорсон тохиолдол бүр онлайн системд бүртгэгдсэнээр ирцийн дүнд нөлөөлнө.
15. Хэрэв сурагч нэг улиралд гураваас дээш удаа хоцорвол эцэг эх асран хамгаалагч нь ангийн багштай нь уулзаж багшид нь ямар учраас хоцорч байгаа шалтгааныг тайлбарлаж, шийдэх хэрэгтэй. Хэрэв хоцролт зогсохгүй удаа дараа давтагдсаар байвал Орлогч захиралтай уулзаж цаашид энэ сургуульд үргэлжлүүлэн суралцах эсэхэд шийдвэр гаргана.
16. Хэрэв сурагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр (эмчид цаг авч үзүүлсэн, эрүүл мэндийн гэх мэт шалтгааныг хүлээн зөвшөөрнө) 10:30 минутаас хойш хоцорч ирвэл хичээл бүтэн өдөр тасалсанд тооцон энэ талаар эцэг эхэд нь нэн даруй мэдэгдэн гэрт нь буцаана.

17. Сурагч хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээлээс эрт гарах бол эцэг эх асран хамгаалагч нь сургуулийн бүртгэлийн ажилтны 70154015 утсанд эхлээд заавал мэдэгдэнэ. Үүний дараа Эрт гарах зөвшөөрлийн хуудсыг зохих журмын дагуу бөглөн гаргана.
18. И Эс Эм Сургуулийн бүх ажилчид, сурагчид, эцэг эх асран хамгаалагчид сургуулийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байгаа жижүүр, харуул хамгаалалт, хүлээн авахын ажилтан нарын ажил үүргийн дагуу тавьсан зүй ёсны шаардлагыг хүлээн авч биелүүлэх үүрэгтэй.

Revisions - Please write your name, the date and action taken.

Action Taken (eg. Write/Review/Edit)	Name, Position	Date
Боловсруулсан	Michael Blake- Орлогч дарга, Connor Vinnicombe-Бага сургуулийн орлогч эрхлэгч	14 th October 2019
Edit	М.Заяа – Цэцэрлэг/ Бага сургуулийн эрхлэгч, менежер	1 November 2019